



УЯХ ЗАНГИДАХ УРЛАЛЫГ СУДЛАН, ЦААШИД СУРГАЛТАД НЭВТРҮҮЛЭХ НЬ

Б.Жаргал^а
^аМУБИС-Багшийн сургууль

Холбоо барих зохиогч: Jargal.b@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.09.03

Хянагдсан: 2025.10.03

Зөвшөөрсөн: 2025.11.10

Хураангуй

Өнөөгийн үйлдвэржсэн нийгмийн нөхцөлд гар урлалын уламжлалын байр суурь буурч байгаа мэт харагдавч түүний өвөрмөц онцлог нь тухайн ард түмний гоо зүй, үзэл санаа, уран чадварын давтагдашгүй илэрхийлэл, соёлын үнэт зүйл хэвээр байна. Монголын уламжлалт уяа зангилаа урлалын талаарх судалгаа ховордож, урлаачдын бүтээл багассанаар энэ өв соёлын уламжлал тасалдах эрсдэлтэй байгаа тул бид энэ асуудлыг судлахаар онцолсон.

Иймээс энэхүү судалгаагаар уламжлалт уяа зангилааны нэршил, төрөл, ангилал болон зангидах технологи дараалал зэргийг судалж, түгээмэл хэрэглэгддэг зангилааны онцлог, хэрэглээ, технологийн зураглалыг шинжиллээ.

Судалгааны үр дүнгээр төрөл бүрийн зангилааг хүснэгтээр ангилан үзүүлж, хэрэглээ болон технологи дарааллыг зурагласан нь ойлгомжтой байдлыг хангаж байна.

Цаашид бага боловсролын сургалтын агуулгад зангидахад хялбар технологитой энгийн болон тоглоомын зангилааны төрлүүдийг оруулах боломжтой эсэхийг тогтоох зорилгод дараах ажлыг чиглүүлсэн юм.

Түлхүүр үг

Уяа, зангилаа, өв уламжлал, арга ажиллагаа

Удиртгал

Хүн төрөлхтний гарал үүсэлтэй хамт үүсэж хөгжиж ирсэн урлалын нэг нь уяа зангилаа бөгөөд хүний ур ухааныг багагүй шаардахаас гадна хүний амьдрал, нийгмийн соёл, шинжлэх ухаан, уран үйлэнд ихээхэн үүргийг гүйцэтгэж иржээ. Урлаач судлаачид энэ урлалын талаар дурдаж, түгээн дэлгэрүүлэхгүй болсон нь нийгэмд мэдрэгдэж, мартагдахад хүрч, үр хойчдоо өвлүүлэх уламжлал алдагдаж буй нь энэ сэдвээр судлах шалтгаан болсон юм.

Хүний нүдэнд үл үзэгдэх зүйлээс сэтгэл оюунд багтамгүй гайхамшигт том үйлийг бүтээх хүртэл хүний нийгмийн хөгжлийн явцад олон зуун жил өнгөрч аугаа их өөрчлөлт гарсан ч урьд үед юу болж өнгөрснийг хүн төрөлхтөн эргэн харж чаддаг нь гайхамшигтай. Гэвч тэдгээрийг өвлөн авч үлдэх, соёл уламжлал үндэсний ур ухааныг цаашид үнэн бодит, үндэсний хэв шинжээр нь авч үлдэн өвлүүлэх нь багш бидний үүрэг билээ.

Энэхүү судалгаанд Монголын уламжлалт уяа зангилааны төрөл, ангилал, зангилааг зангидах технологи дараалал талаас нь түлхүү тодруулан судлахыг зорьсон.

Үндсэн хэсэг

Хүн сүргийн үед ан амьтан агнаж түүнийгээ хооронд нь холбож мөрөн дээрээ тохох, хүчтэй нараас өөрийгөө хамгаалахын тулд агнасан амьтныхаа арьсыг модонд тэлж уяад сүүдэрт нь хоргоддог байсан, өвс ургамал сүлжиж зангидах зэргээр малгай хийдэг, бог мал, үнэг мэт амьтны арьсыг нөмөрч уяж зангиддаг байсан (Наука и жизнь, 1976, 2) зэргээс үзэхэд уяа зангилаа эрт үүссэн гэж үзэх үндэстэй. Энэ үед сэдэж бүтээсэн загвараа эсгэн огтлон зүсэж эхэлснээс хувцас эдлэлийн эсгүүр бий болж, эсгэж бэлтгэсэн эд ангийг эвлүүлж уях, оёх, холбож үдэх, зангидах зэргээр нэгэн хувцас босгосон нь уяа зангилааны төрлүүд үүссэнийг илтгэнэ. Үүний нэг жишээ нь Австрийн 15-р зууны үеийн цайзын зоориноос олдсон эртний уядаг хувцас юм (Ундрах, 2012, до 5).

Шинэ чулуун зэвсгийн үе МЭӨ 8 мянгаас МЭӨ 4 мянган жилийн үе хүний нийгмийн хөгжилд мэдэгдэхүйц өөрчлөлт гарч дан ганц ан агнуур, жимс ногоогоор амьдрах төдийгүй мал аж ахуй газар тариалан эрхлэх болсон. Энэ үеийн эмэгтэйчүүдийн уран үйл малын тоног хэрэгслийг боловсронгуй урлахад чиглэгдэж тоног чимэг хийх ажилд ахиц гарчээ (Цэвээндорж & Сүхбаатар, 2002, х.36). Монгол эмэгтэйчүүд өөрийн орны нүүдлийн болон цаг уурын онцлогт тохируулан хүн ардынхаа хэрэгцээг хувцас, гэр орны бүхий л хэрэгслийг хүчирхэг механизмаар биш гарын хүчээр хийж гүйцэтгэж ирэхдээ уран үйлийн түүхий материалыг тордон боловсруулахаас эхэлдэг байсан учраас мал аж ахуйгаас гаралтай түүхий эдийг тордох анхны боловсруулалт хийх талаар дадлагажсан хүмүүс билээ. Олон зуун жилийнхээ аян жин тээх, амьдралдаа ердийн хөсөг¹ хэрэглэж ирсэнтэй уялдуулж малын тоног хэрэгслийг малчин ардууд өөрсдөө хийж, хэрэглэж ирсэн түүхэндээ олон янзын уяа зангилаа бий болжээ (Сонгино, 2010, х) .

Бид энэхүү судалгаандаа уламжлалт уяа зангилааны нэршил, төрөл, ангилал, зангидах технологи дараалал зэргийг түлхүү судалсан. Уламжлалт уяа зангилааг зангидах арга ажиллагаагаар нь төрөлжүүлэн схемчилж мөн хүснэгтлэн, ангиллын тоо, нэршлийг гаргасан. Төрөл тус бүрд түлхүү хэрэглэгддэг зангилааны хэрэглээ, технологи дарааллын зураг зэргийг судалж хүснэгтлэн оруулсан.

¹ (Монгол хэлний их тайлбар толь- Уналга, ачлага)

Судалгааны үр дүн


Манай орны хүн ард уяа зангилааг эрт үеэс эдүгээ хүртэл хэрэглэж ирсэн боловч одоогоор чухам хэчнээн зангилаа байгааг тогтоосон тоогүй бөгөөд нэг хоёр удаагийн судалгаагаар тоог тоолох нь учир дутагдалтай болно. Судалгааны явцад ажиглаж байхад манайхан уяа, зангилаа хоёрыг тодорхой зааггүй ярих боловч нарийвчлан судалж үзвэл тодорхой ялгаатай байна. Уяа²: гэдэг нь мал амьтныг уяж бэхлэх, ачаа тээш баглаж хүлж уях, гэрийн оосор бүчийг чангалж дарж уях зэрэг бэхэлгээний зориулалттай байдаг. Зангилаа³: гэдэг нь бие даасан тодорхой хэлбэр дүрс үүсгэн урлах эдийг хээлж чимэглэх, бэхэлж тогтоох зэрэгт хэрэглэгддэг онцгой нэг урлаг юм.

Уях зангидах урлал нь нэхмэл сүлжмэлээс ялгаатай бөгөөд уях зангидах урлалыг нэхмэл сүлжмэлтэй хослуулан урлаж бүтээх нь түгээмэл байдаг учраас нэг урлал гэж андуурах нь элбэг байдаг. Нэхмэл сүлжмэлийг нарийвчлан авч үзвэл гурваас дээш тооны бэлдцээр хийх гөрмөл⁴ нэг утсаар сүлжих, тусгай суурь дээр нэхэх зэрэг аргын ялгаатай хэлбэр гарч ирнэ. Утсыг нугаруулах замаар гогцоо үүсгэн өөр хооронд нь хэрж холбосон эдлэлийн урлалыг сүлжмэл гэнэ. Сүлжмэлийн үндсэн элемент нь гогцоо бөгөөд гогцоо нь тодорхой хэлбэр бүхий огторгуйн муруй шугам юм (Энхмаа, 2002, х.).

Ахуйн хэрэглээний зайлшгүй шаардлагаар үүсэн гарч нийгэм дэвшин хөгжихөд асар их үүрэг гүйцэтгэсэн чухал хэрэглэгдэхүүний нэг нь уяа зангилаа юм. Уяа зангилааны эхлэл нь энгийн дан зангилаанаас эхлэн хэд хэдэн янзаар давхарлах болон мөчир салаа гарган дүрс үүсгэж болдгоороо урлагийн нэг том бие даасан салбар болдог (Бат-Очир, 2004, х.).

Уях зангидах урлалын төрөл: Уяа зангилааг зангидах⁵ арга ажиллагаагаар нь хэд хэдэн бүлэг, төрөл болгон хуваадаг байна. Эдгээрийг схемчлэн доор харуулав.

Схем 1. Уламжлалт уяа зангилааг зангидах арга ажиллагаагаар төрөлжүүлсэн байдал



2 (Монгол хэлний их тайлбар толь-Оосор, бүч, цулбуур зэргийг зангидах арга)

3 (Монгол хэлний их тайлбар толь- Оосор бүч, утас шөрмөс зэргийн уяж залгасан газар, зангидсан уяа)

4 (Монгол хэлний их тайлбар толь- Гөрж сүлжиж хийсэн юм)

5 (Монгол хэлний их тайлбар толь- Юмыг зангидах, занги болгох, үхлүүт уях:)

Уяа зангилааг энгийн бөс бараа төрөл бүрийн утас, дээс⁶ сур⁷-аас эхлэн төмөр, мод хатуу эдээр зангидан дүрс үүсгэнэ. Жирийн төмөр утас, техникийн олон давхар төмөр утас Канадын далайчин зангилаа, 6 ширхэг модноос эхлэн 600 гаруй мод углуургадан зангидаж оньсон зангидмал тоглоом хийхээс эхлэн олон давхар барилгын яс модыг нэг ч хадаасгүй зангидан байшин барилга, хот тосгон сүндэрлүүлдэг модон зангилаа зэргүүдийг хүн төрөлхтөн урлан бүтээж иржээ. Эдгээр уран зангилааны төрлүүд нь тус тусдаа хэд хэдэн янзаар ангилагддаг ба ангиллыг хүснэгтлэн доор оруулав.

Хүснэгт 1. Зангидах арга ажиллагааны төрөл, ангилал

№	Энгийн зангилааны ангилал	Гоёлын зангилааны ангилал	Уран сэтгэмжийн буюу тоглоомын зангилааны ангилал
1.	Дан зангилаа	Цацаг зангилаа	Утсаар дүрс гаргах зангилаа
2.	Давхар зангилаа	Моголцог ⁸ зангилаа	Цахилдаг сүлжиж, зангидах
3.	Цулбуур ⁹ шонд уях хөвөрхий зангилаа	Өлзий ¹⁰ зангилаа	Гарын хуруугаар зангидах
4.	Цулбуурын халх зангилаа	Хагас өлзий зангилаа	Модон оньс
5.	Цулбуурын Буриад зангилаа	Өлзий голтой цацган зангилаа	Гархин цоож
6.	Занги зангилаа \гэрийн бүслүүрийн\	Өлзий голтой хамар угалзан зангилаа	Тод төмөрлөгөөр үйлдсэн, угсрах, эвлүүлэх, задруулах, гаргах наадгай
7.	Хуаз ¹¹ зангилаа	Туухай ¹² зангилаа	Модон зангилаа оньсон тоглоом
8.	Үйлчин зангилаа	Өлзий туухайтай, цацагтай зангилаа	Монгол түлхүүр тоглоом
9.	Тооно туших зангилаа	Бумбан ¹³ зангилаа	Уран ээдрээт тоглоом
10.	Чих зангилаа	Цацагтай өлзий голтой бумбан зангилаа	
11.	Дан хазаар ногтны зангилаа	Сампин ¹⁴ зангилаа	

6 (Монгол хэлний их тайлбар толь- Үс хялгас, олс зэргээр томж хийсэн оосор:)

7 (Монгол хэлний их тайлбар толь- Идээлж болгосон шир арьсыг элдэж урт зүссэн нь;)

8 (Монгол хэлний их тайлбар толь-Үзүүр мухар бөгөөд хэвийн хэмжээнээс богино, гонзгой, бөөрөнхий байдал;)

9 (Монгол хэлний их тайлбар толь- Морь малыг хөтлөх, уяхад зориулж, хазаарын амгай зуузаг, ногтонд бэхэлсэн дээс, суран урт оосор:)

10 (Монгол хэлний их тайлбар толь-Энх амгалангийн төгөлдөр бэлгэдэлт, ханан хээ;)

11 (Монгол хэлний их тайлбар толь- 1.Модны үрээс гаргасан будаг; 2. Хятад хүмүүс)

12 (Монгол хэлний их тайлбар толь-Нэгэн зүйл угалзан зангилаа: туухай зангидах (а. Горхи горхидох; б. Битүү гогцоо гарган зангидах нэг зүйл зангилаа).

13 (Монгол хэлний их тайлбар толь-Найман тахилын гуравдугаарт ордог алт, мөнгө, зэс, гууль тэргүүтнээр хийсэн рашаан агуулах өндөр хүзүүтэй, бариулгүй сав:)



14 (Монгол хэлний их тайлбар толь-1.Бөс торгыг нарийн жишүү зурвас хайчилж, шилбэ ёмхэрдэн зангидсан монгол дэвлийн товч;-2. Дэвлийн товч адил зангидсан малгайн оройд хаддаг чимэг;)

12.	Давхар хазаарын зангилаа	Сампин голтой, сүлжмэл тавтай давхар цацган зангилаа	
13.	Захилдаг зангилаа	Олбог ¹⁵ зангилаа	
14.	Чөдрийн алхан зангилаа	Аман хүзүү зангилаа	
15.	Чөдрийн хөх ¹⁶ ний зангилаа	Цэцэг зангилаа	
16.	Битүү тугалчин зангилаа	Цэцгэн туухай зангилаа	
17.	Задгай тугалчин зангилаа	Бэл ¹⁷ цэцгэн зангилаа	
18.	Сүлжээ зангилаа	Эрвээхэй зангилаа	
19.	Ташуурын зангилаа	Хөндлөн зангилаа	
20.	Бурантаг ¹⁸ ны зангилаа	Үнэгэн чих зангилаа	
21.	Бөгжин зангилаа	Очир зангилаа	
22.	Гогцоо зангилаа		
23.	Хонин холбоо зангилаа		

Уран зангилааны ангилалд орсон эдгээр зангилаанууд нь тус бүрдээ өөр өөрийн гэсэн хэрэглээ, зангидах технологи дараалалтай бөгөөд заримаас нь дэлгэрүүлэн доор бичив.

Энгийн зангилаа: Бэхэлгээний буюу энгийн зангилаа нь анхдагч зангилаа юм. Энгийн зангилааны өргөн хэрэглэгддэг зарим ангиллыг хэрэглээ, нэршил, зангидах технологи дарааллын зураг зэргийг судлан хүснэгтлэн оруулав.

Хүснэгт 2. Энгийн зангилааны ангилал, нэршил, хэрэглээ, зангидах технологи дарааллын зураг

№	Энгийн зангилааны нэршил	Хэрэглээ	Зангидах технологи дарааллын зураг
1.	Дан зангилаа	Энэ зангилаа нь хэрэглээнд өдөр тутам хэрэглэгдэж байдаг зөөлөн эдийн хоёр үзүүрийг нийлүүлж нэгээс хоёр удаа уяж зангидах ердийн зангилаа юм. Төдийлөн бат бэх биш зангилаа боловч одоо хүртэл нийтлэг хэрэглэгдсээр байна.	
2.	Хөвөрхий зангилаа	Морины цулбуур ¹⁹ г шонд уяхад энэ зангилааг хэрэглэнэ.	






15 (Монгол хэлний их тайлбар толь-Эсгийг цэмбэ, торго зэргээр өнгөлж хийсэн хүн суухад зориулсан дөрвөлжин дэвсгэр;)

16 (Монгол хэлний их тайлбар толь-Чөдрийн чагт торгоох гогцоо.)

17 (Монгол хэлний их тайлбар толь-Хэт хутга зэргийн юмыг зүүх оосрын чимэг;)






18 (Монгол хэлний их тайлбар толь-Тэмээний буйлнаас уяж хөтлөх хоёроос гурван метр орчим урт нарийн дээс;)

19 (Монгол хэлний их тайлбар толь- Морь малыг хөтлөх, уяхад зориулж, хазаарын амгай зуузай, ногтонд бэхэлсэн дээс, суран урт оосор;)

3.	Үйлчин зангилаа	Оёдол үйлийн утасны учигын үзүүр зангидах, дээс, олс, сүлжмэл, томмолын үзүүрийг задлан алдагдахаас хамгаалах буюу эд материалын гоёлд тээглүүр маягаар хэрэглэнэ.	
4.	Тооно туших зангилаа	Хүн эрт үеэс хэрэглээнд хэрэглэсэн энгийн хялбар мөртлөө хамгийн баг бөх зангилаа. Дэлхийд далайчин зангилаа гэж алдаршсан.	
5.	Хонин холбоо зангилаа	Хонь холбоход өргөн хэрэглэдэг бөгөөд нэг гогцооноос бусад гогцоог гогцоолдон хэлхэнэ. Богц, даалин мэт нэгийг нөгөөгөөр дарж үдэх, амтай савны амыг бэхлэхэд хэрэглэнэ	
6.	Тугалчин зангилаа	Уургад хуйв, шилбүүрт сур бэхлэхэд хэрэглэх бөгөөд модондоо тээглүүр зорж гаргаад түүнийхээ доод талд зангидах хуйв буюу сурынхаа үзүүрийг зөрүүлэн чангалах ба хуйванд бас нэмэлт зангилаа хэрэглэнэ.	
7.	Чих зангилаа	Хазаар, ногт, чөдөр, зангидах зангилаа тус бүр өөр өөр байдгаас бэхэлгээнд хуаз, тугалчин, чих, занги, хөвөрхий гэх мэт олон зангилаа бий болсон.	
8.	Хазаар ногтны зангилаа		
9.	Хуаз зангилаа		




Гоёл чимэглэлийн зангилаа: Хувцас эдлэлийг чимж өнгө үзэмж оруулахад зориулагдсан зангилаа нь гоёл чимэглэлийн зангилаа юм. Эдгээр зангилааг зангидахад хүний хөдөлмөр ур ухааныг ихэд шаардана. Гоёл чимэглэлийн зангилааны өргөн хэрэглэгддэг зарим төрөл ангиллыг хэрэглээ, нэршил, зангидах технологи дарааллын зураг зэргийг судлан хүснэгтлэн оруулав.

Хүснэгт 3.Гоёл чимэглэлийн зангилааны ангилал, нэршил, хэрэглээ, зангидах технологи дарааллын зураг

№	Гоёлын зангилааны нэршил	Хэрэглээ	Зангидах технологи дарааллын зураг
1.	Сампин зангилаа	Олон зуун жил хэрэглэгдэж ирэхдээ өөрчлөгдөөгүй туйлын боловсронгуй зангилаа юм. Дээл малгайн сампинг хийдэг.	
2.	Цэцгэн зангилаа	Бэл зангилааг дарааллаар нь олон удаа давтахад цэцэг хэлбэртэй болох ба үүнийг цэцэг зангилаа гэнэ. Сүүлийн үед дан дээлийн шилбэ товчийг өөр хэлбэрээр зангидах боллоо. Үүнд хавтгай, угалз маягийн, цэцгэн зангилаа зэргийг хэрэглэх болсон нь орчин үед тохирсон ур хийц сайтай гоёмсог зангилаанууд юм.	
3.	Моголцог зангилаа	Хувцасны чимэгт моголцог буюу цацган зангилааг хэрэглэдэг. Нарийн бүчийг дугуйлан гоёмсог хэлбэрт оруулж чимэглэх зангилаа бөгөөд хувцас, эмээл, хазаар ногтны тоногт хэрэглэнэ. Утас, сур, даавууны нарийн өөдсөөр хийх бөгөөд хэсэг утас буюу цацаг хийх нарийн материалыг нийлүүлэн утсаар ороож нарийхан толгой гаргаад түүнийгээ эргүүлж утсаараа бүрхүүлж толгой гарган толгойгоо утсаар жигд ороож бэхэлнэ. Хувцас, бурхны хөрөг чимэх, дамрын жавдан ²⁰ , малгайн жавдан бүч, эмэгтэй хүний гоёл чимэглэлийн зүүлт, морины хударга ²¹ ны чимэгт хэрэглэдэг	
4.	Аман хүзүү зангилаа	Энэ зангилааг гоёл, чимэглэл бусад бэхэлгээнд хоёр янзаар хэрэглэдэг бөгөөд нэг голын дээгүүр доогуур нь оруулан бөгжлөн шахаж зангиддаг. Зангидах нарийн бүчээ \савхи, утас даавуу\ хоёр бүтэн ороож дараа нь зөрүүлж баруун зүүн тийш нь сүлжээд 3 дахь бүчээ хоёр сүлжээсний дундуур нь хоёр тийшээ дахин давтан сүлжихэд гурамсан аман хүзүү зангилаа буй болно.	
5.	Өлзий зангилаа	Үүнийг зангидахад утсаар буюу торгоор зангидна. Хэрэв торгоор тавих бол өлзийн өнцөг, буланг тэгш цэвэр гарган нааж бэлтгээд чимэглэх эдийнхээ зайд тохируулан тавьж оёно.	

20 (Монгол хэлний их тайлбар толь-Хурлын лам нарын суудлын налуу тавцантай, олбог бүхий түшлэг, урт өнгөц, зиндаанаас хамаарч суудлын өндөр, нам, олбогын өнгө ялгаатай)

21 (Монгол хэлний их тайлбар толь-Эмээлийн хавтасны хойд талд уяж, морь малын сүүл бөгсөнд тогтоох бэхлэгээ оосор)

6.	Өлзий туухай зангилаа	Өлзий туухайг зангидахдаа зүүн гартаа нэг, баруун гартаа хоёр тэнцүү хэмжээтэй гогцоо атгалж эхний гогцоон дундуур сүвлэн гаргаж баруун талын хоёр гогцоон дундуур дээрээс нь доош нь хоёр гогцоог сүвлэж гаргаад үзүүрээсээ буланд нь битүү гогцоо үүсгэн баруун талын хоёр гогцооны дундуур дээд талаас шургасан хоёр гогцооны завсраар оруулан эхний гогцоог дарж, буцааж дээд гогцооны завсраар дахин гогцоо үүсгэн түрүүчийн адил дээд гогцооны дундуур орсон үзүүрийг давхраар нь дарж гаргаад үзүүрээр нь гогцоо үүсгэн дээрээс шургасан хоёр гогцооны дундуур хөндлөн дөрвөн гогцооны дээгүүр доогуур нь сүлжин буцааж гаргана. Тойрсон битүү гогцоогоо тэнцүүлэн чангалахад өлзий туухай болно	
7.	Хөндлөн туухай зангилаа	Үүнийг зангидахдаа зүүн гартаа нэг урт гогцоо гарган дээш нь урт богиноор тэнцүү хэмжээтэй дөрвөн гогцоо сүвлэн гаргахын хамт баруун талаас нь нэг урт гогцоо гаргана. Баруун талаас сүвлэн гаргасан гогцооны үзүүрээр гогцоо гарган баруун талын хоёр босоо гогцооны дундуур, дээд талын гогцооны завсраар доод талын гогцоог битүү хоёр удаа дарж, дээд талдаа гогцоо үүсгэн дээш нь гаргана. Зүүн талын нэг үзүүрийг доод талын захын гогцоон дундуур цааш гарган мөн түрүүчийн адил зүүн талын гогцоон дундуур доод талын гогцоог битүү дарж гаргаад гогцоонуудаа чангална.	
8.	Эрвээхэй зангилаа	Энэ зангилаа нь өлзийн голын хоёр талын хоёр, хоёр гогцоог хооронд нь зангидан аман хүзүү буюу жирмэн ²² угалз үүсгэн зангидна. Жирмэн угалз үүсгэхдээ голын гогцооны хоёр талын гогцоог урт гогцоолдон сүлжээд дараагийн гогцоо гаргахдаа зурагт үзүүлснээр дэс дараагаар дээгүүр, доогуур нь оруулж зангидна. Ингэхэд хэрэв зангилаа зөв хийгдсэн бол далавчтай эрвээхэй маягийн хээ гарна.	

Сурын зангилаа: Сураар хазаар ногт, чөдөр, тушаа гэх мэт олон төрлийн энгийн зангилаа зангидахаас гадна малын тоног хэрэгсэл болон ширэн эдэд гоёл чимэглэлийн олон төрлийн зангилаанууд байдаг. Малын тоног хэрэгслийн сурын зангилаанууд цөм хавтгай байдаг нь малын бие үрж холгох, тоног хэрэгслийн үзэмжийг дардаг тул заавал хавтгай зангидна. Морины хазаар, ногт, чөдөр, эмээл зэрэг нь 61 хэсгээс бүрдэх тул түүнийг хооронд нь холбож бэхлэхэд доорх зангилаа, гогцоо, уяа зэрэг эд анги ордог. Мөн ат, морь, шарыг уналга, ачлага, хөллөгөөнд ашиглахад 27 тоног хэрэгслийн 389 эд ангийг бүрдүүлдэг ба эдгээрийг хүснэгтлэн тоог харуулав.

22 (Монгол хэлний их тайлбар толь-Эмээлийн олмыг гогцоонд нь оруулж чангалдаг гөрмөл сур)

Хүснэгт 4. Хазаар ногт, чөдөр, эмээл зэргийг хооронд нь холбож бэхлэхэд хэрэглэгдэх эд ангийн тоог уналга, ачлага, хөллөгөөнд ашиглах эд ангийн тоотой харьцуулсан байдал

Эд анги	Зангилааны төрөл	зангилаа	гогцоо	уяа	Төмөр цагариг	Төмөр гогцоо	Арал, гархи, сүлжээ	Нүх	Модны углуурга заадас	Төмөр даруулга
Хазаар ногт, чөдөр, эмээл	Хавтгай, сүлжмэл	13	25	24	5	5	31	60		
Уналга, ачлага, хөллөгөө	Хавтгай, сүлжмэл	32	82	100	24	23	22	205	300	20

Уран сэтгэмж буюу тоглоомын зангилаа: Гарын арван хуруундаа битүү утас гогцоолдон түргэн хугацаанд олон төрлийн дүрс болох майхан, уран бүсгүйн хайч, хана, галуун таваг, онгоц, хаалга гэх мэт зүйлсийг үүсгэн зангидах, цахилдаг зангидан сүлжих, гарын арван хуруугаар сүмбэр уул зангидах, модон оньс, гархин цоож, тод төмөрлөгөөр үйлдсэн: угсрах, эвлүүлэх, задруулах, гаргах наадгай гэх зэрэг Монгол ардын уламжлалт олон төрлийн оньсон тоглоомууд байдаг. Оньслох тоглоомд даруулах, шургуулах, давуулах, дагуулах, ороох, углах, өшиглүүлэх, тээглүүлэх, нэхээс, сүлжээс зэрэг гол үйлдлүүд байна.

Уяа зангилаа нь бусад улс оронд уран зангилаа буюу макраме нэршлээр дэлгэрсэн. Мексикт үүссэн гэж үздэг ба утсаар зангидах урлаг юм гэж тодорхойлжээ. Зангилааны тухай шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлолтыг анх Германы эрдэмтэн, математикч, одон орон судлаач Иоган Бенедектин Листинг дэвшүүлсэн байна. Түүний тодорхойлсноор “Зангилаа гэдэг бол огторгуй дах олон төрлийн муруй шугамын огтлолцлын бодлого юм” гэж үзсэн байна. Уран зангилаа ба макрамегын ангилал төрлүүдэд: бэхэлгээний, мушгиа, мөрийн, хавтгай, гинжин зангилаанууд багтана. Энэ зангилаагаар хувцас, бүс, бугуйвч, зүүлт, түлхүүрийн оосор гээд ямар ч хэлбэр дүрс гаргаж амьтан бүтээхээс эхлэн томоохон хэмжээний урлагийн бүтээл байшин барилгын ханын чимэг гэх мэтээр бүх л төрлийн зүйл хийж байгаа нь энэ урлал нь урлаг болтлоо хөгжсөнийг илэрхийлж байна.

Дүгнэлт

Уламжлалт уях зангидах урлалыг судлан, цаашид сургалтад нэвтрүүлэх талаар дараах дүгнэлтэд хүрлээ. Энэ урлал нь эрт үед хүний хөгжилтэй хамт үүссэн цагаасаа эхлэн Монгол үндэсний гар урлалын нэгээхэн том хэсэг болоод зогсохгүй ахуйн хэрэглээнд болон гоёл чимэглэл, тоглоом наадгай зэргээр хөгжиж иржээ. Хөгжлийн явцад анхны хэлбэр дүрс үндсэн зангидах технологи дараалал нь алдахгүйгээр хөгжиж ирсэн ба үндсэн зангилаануудыг хооронд нь хослуульж, урлах арга барил нь шинэчлэгдэн, төрөл, ангилал нь улам баяжигдсаар байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа.

Уях зангидах урлалыг төрөл ангилал болгохдоо зангидах арга ажиллагаа буюу технологи дарааллаар нь төрөлжүүлсэн. Одоогоор бид энгийн зангилааны 23 ангилал, гоёл чимэглэлийн зангилааны 21 ангилал, тоглоомын зангилааны 9

ангиллыг тодрууллаа. Нийт 4 төрөл 53 ангиллыг тодруулав. Энгийн зангилааны төрөл нь голчлон ахуйн хэрэглээнд тогтмол ашиглагдаж ирсэн бол гоёл чимэглэлийн зангилаа нь ахуйн хэрэглээнд болоод гоёл чимэглэлд ашиглагдаж иржээ.

Цаашид бага боловсролын хөтөлбөрийн агуулгад уяа зангилааны энгийн төрөл, ангиллаас хялбар зангидах технологи дараалал бүхий зангилаа, тоглоомын зангилааны төрлүүдээс тусгаж болох тал дээр судалгааг дэлгэрүүлэн судлах нь зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Мөн Монголын уламжлалт уяа зангилаа нь бусад улс оронд макраме нэршлээр дэлгэрсэн уран зангилаанаас юугаар ялгаатай болохыг тодруулж судлах нь үр хойчдоо энэ урлалыг өвлүүлэхэд дөхөмтэй гэж үзлээ.

Ном зүй

1. Бат-Очир, Р. (2004). Урлахуйн гайхамшиг. Улаанбаатар хот:
2. Бийраа, Р. (2004). Ноос утсаар урлахуй. Улаанбаатар хот:
3. Гэвшээхүү, Д. (1970). Монгол ардын гар урлалын уламжлал. Улаанбаатар хот:
4. Нямсүрэн, С. (2013). Монгол ардын уламжлалт тоглоом. Улаанбаатар хот:
5. Сонгино, Ч. (1989). Монгол эмэгтэйн уран үйл. Улаанбаатар хот:
6. Сонгино, Ч. (2009). Монгол малын арьс шир арьсан эдлэл, тоног хэрэгсэл. Улаанбаатар хот:
7. Сонгино, Ч. (2010). Монголчуудын үйл урлахуйн ухаан. Улаанбаатар хот:
8. Сономцэрэн, Л. (1985). Монголын эртний соёл урлаг. Улаанбаатар хот:
9. Цэвээндорж, Д., Сүхбаатар.Б (2002). Хүн төрөлхтний эртний түүх. Улаанбаатар хот:
10. Энхмаа, А. (2002). Гар сүлжмэл. Улаанбаатар хот:
11. Ядамжав, Ц. (2004). Монгол ардын гар урлал. Улаанбаатар хот:
12. Болховитинов, В.Н. (1976). Макраме урлал. Наука и жизнь, 2. ОХУ
13. Ундрах, Д. (2012, 7, 18). Эртний дотуур хувцас олдov. <https://www.24tsag.mn/a/14726>

EXPLORING THE ART OF KNOT TYING AND ITS INTEGRATION INTO EDUCATION

^aJargal B.

^aTeachers School, MNUE

Corresponding author: Jargal.b@msue.edu.mn 

Abstract

Although the status of traditional crafts appears to be declining in today's industrialized society, their unique characteristics continue to serve as an irreplaceable expression of a nation's aesthetics, values, craftsmanship, and cultural heritage. Research on traditional Mongolian knot tying has become increasingly rare, and the number of artisans practicing this craft has diminished, posing a risk to the continuity of this cultural tradition. Therefore, this study was undertaken to address this issue.

The research examined the terminology, types, classification, and tying techniques of traditional Mongolian knots, as well as the sequence and technology involved in their creation. The characteristics, uses, and technical schematics of commonly used knots were analyzed in detail.

As a result, the study presented a clear classification of various knot types in tabular form, along with illustrations of their applications and tying procedures to ensure comprehensibility. Furthermore, the research aimed to explore the potential for integrating simple and playful types of knots—those with easy tying techniques—into the primary education curriculum.

Keywords

Knot tying, traditional knots, cultural heritage, techniques, craftsmanship
